



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 11 сарын 03 өдөр

Дугаар 5/184

Улаанбаатар хот

Г Батнямын Өнөрхүүг түр орлон

гүйцэтгэгчээр томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.18 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 9 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулалт олгох журам", Авлигатай тэмцэх газрын 2023 оны 11 дүгээр сарын 03 -ны өдрийн 01/17827 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Батнямын Өнөрхүүг гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь зэрэгцээ Дархан -Уул аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр 2023 оны 11 дүгээр сарын 03 -ны өдрөөс эхлэн тухайн албан тушаалд сонгон шалгаруулалт зохион байгуулж, дүн гарч шийдвэрлэх хүртэлх хугацаагаар томилсугай.

2. Б. Өнөрхүүгийн ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн дотор хүлээнцүүлэх Ажлын хэсгийг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн  
ахлагч

Л.Төгсбаяр

Боловсрол, шинжлэх ухааны  
яамны Салбарын хяналтын газрын  
дарга

Ажлын хэсгийн  
гишүүд

Д.Өнөржаргал

Боловсрол, шинжлэх ухааны  
яамны Салбарын хяналтын газрын  
шинжээч

Ч.Баярмаа

Боловсрол, шинжлэх ухааны  
яамны Хууль эрх зүйн хэлтсийн  
ахлах шинжээч

М.Нямханд

Боловсрол, шинжлэх ухааны  
яамны Дотоод аудитын хэлтсийн  
шинжээч

Т.Ичинхорлоо

Дархан-Уул аймгийн Боловсрол,  
шинжлэх ухааны газрын  
ерөнхий нягтлан бодогч

1231 1844

Ажлын хэсгийн  
нарийн бичгийн  
дарга

Д.Одончимэг

Боловсрол, шинжлэх ухааны  
яамны Төрийн захиргааны  
удирдлагын газрын шинжээч

3. Б.Өнөрхүүд албан үүргийг түр орлон гүйцэтгэсэн цалингийн зөрүүг тооцож олгохыг Дархан-Уул аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын ерөнхий нягтлан бодогч (Т.Ичинхорлоо)-д зөвшөөрсүгэй.

4. Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, орон нутгийн боловсролын сургалтын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхэд захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангаж, дэмжлэг үзүүлэх, холбогдох хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнах, удирдах ажилтны ёс зүй, манлайлал, шуурхай байдлыг эрхэмлэж ажиллахыг Б.Өнөрхүүд үүрэг болгосугай.

5. Б.Өнөрхүүтэй үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, удирдлагын манлайлал, эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Отгонцэцэг)-т, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газар, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар (П.Оюунаа)-т, үр дүнгийн гэрээний явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар (Н.Нарангэрэл) -т тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг баталсантай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн “Гарын үсэг зурах эрх олгох тухай” А/434 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

7. Дархан-Уул аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, дүнг танилцуулахыг Төрийн албаны зөвлөлийн Боловсрол, шинжлэх ухааны яамны дэргэдэх салбар зөвлөл /Л.Цэдэвсүрэн/-д даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН